



“ПАНТЕР МИДЛАНД АУДИТ” ХХК

**“БИ ДИ СЕК ҮЦК” ХК
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**2023 оны 12 сарын 31-нээр дуусгавар
болгосон аудитын тайлан**

Улаанбаатар хот

2024 он



**"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН
2023 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

<u>АГУУЛГА</u>	<u>ХУУДАС</u>
Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу.	
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг Утас: 976-7013-1770 Гар утас: 9511-1770	Удирдлагын хариуцлагын мэдэгдэл.....2
Аудитор: Ц.Алтанцэцэг Гар утас: 9511-1770 Туслах аудитор: Ш.Бямбаа Утас: 97111770	Хараат бус аудиторын тайлан3-5
Чанарын хяналтын аудитор Б.Сансармаа Гар утас:	Санхүүгийн байдлын тайлан6
Аудиторын туслах Д.Батсайхан Т.Энхсайхан	Орлогын тайлан7-8
	Мөнгөн гүйлгээний тайлан9
	Өмчийн өөрчлөлтийн тайлан10
	Санхүүгийн тайлангийн тодруулга, компанийн товч мэдээлэл, танилцуулга11-12
	Тайлангийн хураагуй.....13
	Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй15-21
	Санхүүгийн тайлангийн тодруулга22-29

"Пантер мидланд аудит" ХХК
Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Нарны
зам 81, JS tower 1002 тоот
e-mail: info@pma.mn
fax: 976-7014-1770

Вэб хуудас: www.pma.mn


2024 оны 03 дугаар сарын 12

**2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар
болгосон жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлан
бэлтгэх болон батлах талаарх Удирдлагын
Хариуцлагын Мэдэгдэл**


Энэхүү тайлангийн 6-10 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Би Ди Сек ҮЦК" ХК болон түүний охин компани "Би Ди Си Эй Пи" ХХК, "Их Чингис Хааны хөмрөг" ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусд нь харуулах зорилгоор хийгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид эдгээр нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа СТОУС, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.


Д.Даянбилгүүн
Төлөөлөн Удирдах
Зөвлөлийн дарга


Б.Лхагвадорж
Гүйцэтгэх
Захирал


Д.Даваасүрэн
Ерөнхий Нягтлан
Бодогч

Улаанбаатар хот, Монгол улс
2024 оны 02 дугаар сарын 12-ны өдөр

Хаяг: JS Tower 10-р давхар - 1002 тоот - Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нарны зам
Улаанбаатар хот, Монгол улс

Утас:(976) 7013 1770
Факс:(976) 7014 1770

Огноо: 2024.03.16

№ 24/09

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Зөрчилгүй санал дүгнэлт

Бид 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Би Ди Сек ҮЦК" ХК болон түүний охин компани "Би Ди Си Эй Пи" ХХК, "Их Чингис Хааны хөмрөг" ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Энэхүү дүгнэлт нь хавсаргасан санхүүгийн тайлангууд болон 12-29 хүртэлх хуудсан дахь тэмдэглэлийн хамтаар хүчин төгөлдөр болно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Компани нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч, хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүсэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг дуусах өдөр хүртэлх хугацаанд аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Номинал дансны талаар

"Би Ди Сек ҮЦК" ХК нь өөрийн харилцагчдын арилжааны төлбөр тооцоотой холбоотой мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх, удирдах зорилго бүхий Худалдаа Хөгжлийн банканд байрших, 452644001 ам долларын, Голомт банканд байрших 1105391344 тоот ам долларын данс, Голомт банкны 1105057130 тоот төгрөгийн, Богд банкинд байрших 8160011183 тоот номинал дансны харилцагчийн мөнгөн гүйлгээний тайланг банкны хуулга болон анхан шатны баримт, мөнгөн хөрөнгө дамжсан данс бүрээр нь тулган шалгахад Санхүүгийн Зохицуулах Хорооны "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам", байгууллагын "Харилцагчийн мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо, гүйлгээний журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хөтөлсөн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно.



"Пантер Мидланд Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал Ц.Алтанцэцэг

АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
"БИ ДИ СЕК ҮЦК" ХХК

(төгрөгөөр)

Дансны нэрс	1/1/2023	12/31/2023
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн бус хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,660,936,353.93	2,898,220,700.29
Дансны авлага	3,127,553,537.25	2,480,091,489.23
Бусад авлага	241,913,068.02	663,586,404.43
Бусад санхүүгийн хөрөнгө	26,172,741,305.45	34,042,464,947.26
Холбоотой талаас авах авлага	760,826,678.04	124,707,512.67
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	133,059,243.46	443,961,599.46
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	33,097,030,186.15	40,653,032,653.34
Эргэлтийн хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4,381,510,296.20	4,286,593,093.38
Биет бус хөрөнгө	40,864,320.60	36,671,697.21
Урт хугацаат хөрөнгө оруулалт	51,000,000.00	51,000,000.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	4,473,374,616.80	4,374,264,790.59
НИЙТ ХӨРӨНГӨ	37,570,404,802.95	45,027,297,443.93
ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	1,156,799,486.23	1,567,061,210.71
Цалингийн өглөг	40,409,163.52	68,449,673.74
Орлогын татварын өглөг	166,845.07	34,545,907.63
ХАОАТ-ын өглөг	20,865,477.25	31,161,930.12
ҮХХТ-ын өглөг	3,469,200.00	0.00
НӨАТ өглөг	939,882.18	1,272,238.52
Урьдчилж орсон орлого	477,871.19	477,871.18
Векселийн өглөг	377,938,477.04	0.00
Нөөц (өр төлбөр)	41,084,649.00	41,084,649.00
Бусад богино хугацаат өр төлбөр	999,831,700.91	0.01
Бусад өглөг /Номинол/	168,584,869.68	615,306,696.09
Хүүний өглөг	0.00	2,597,980.80
ЭМНД-ийн шимтгэлийн өглөг	24,438,131.88	33,769,802.93
Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,835,005,753.95	2,395,727,960.73
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл	20,592,499,677.94	27,327,536,422.46
Урт хугацаат өр төлбөрийн дүн	20,592,499,677.94	27,327,536,422.46
Нийт өр төлбөр	23,427,505,431.89	29,723,264,383.19
Эзэмшигчдийн өмч		
Өмч: - төрийн	0.00	0.00
- хувийн	1,369,488,300.00	0.00
- хувьцаат	0.00	9,326,763,118.32
Халаасны хувьцаа	0.00	
Нэмж төлөгдсөн капитал	7,957,309,291.00	34,472.68
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,824,524,382.82	3,824,524,382.82
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	
Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	(600,193,925.70)	(600,193,925.70)
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,591,771,322.94	2,752,905,012.62
Эзэмшигчдийн өмчийн дүн	14,142,899,371.06	15,304,033,060.74
НИЙТ ӨМЧ, ӨР ТӨЛБӨР	37,570,404,802.95	45,027,297,443.93

12-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
"БИ ДИ СЕК ҮЦК" ХХК

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО			
1.1.1	Үйл ажиллагааны орлого:	2,467,961,884.26	4,873,387,264.97
1.1.1.1	Брокерийн үйл ажиллагааны	209,782,656.24	1,677,612,491.78
1.1.1.2	Андеррайтерийн үйл ажиллагааны	1,844,881,146.17	784,616,211.50
1.1.1.3	Хөрөнгө оруулалт менежмент хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээний	20,716,112.92	40,750,000.00
1.1.1.4	Үнэт цаасны арилжааны цэвэр орлого	392,581,968.93	2,286,270,394.08
1.1.1.5	Диллерийн үйл ажиллагааны орлого	0.00	84,138,167.61
1.1.2	Хөрөнгө оруулалтын орлого	995,780,700.00	476,893,322.03
1.1.2.1	Компанийн бондын хүүгийн орлого	544,518,046.92	0.00
1.1.2.2	Ногдол ашгийн орлого	149,583,739.36	109,711,735.73
1.1.2.3	Бусад орлого	141,531,542.80	169,710,946.66
1.1.2.4	Түрээсийн орлого	160,147,370.92	197,470,639.64
1.1.2.5	Хүүний орлого	0.00	1,460,648,306.75
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		3,463,742,584.26	6,810,928,893.75
1.3	Нийт ашиг /алдагдал/	3,463,742,584.26	6,810,928,893.75
1.4	Үйл ажиллагаа /борлуулалт, ерөнхий удирдлага/-ын зардал		
1.4.1	Үндсэн болон нэмэгдэл цалин	996,306,126.50	1,408,554,546.50
1.4.2	Нийгмийн даатгалын шимтгэл	123,947,781.87	175,278,716.50
1.4.3	Засвар үйлчилгээний зардал	142,162,351.91	82,226,304.55
1.4.4	Ашиглалтын зардал /интернет, түрээс/	114,450,735.92	117,674,352.99
1.4.5	Сургалтын зардал	7,139,000.00	6,142,000.00
1.4.6	Албан томилолтын зардал	5,261,659.00	61,643,125.93
1.4.7	Бичиг хэргийн зардал	44,951,160.00	45,777,919.38
1.4.8	Тээврийн зардал	540,500.00	0.00
1.4.9	Шатахууны зардал	24,179,647.00	24,771,376.00
1.4.10	Аж ахуй хангамжийн материалын з зардал	0.00	0.00
1.4.11	Элэгдлийн зардал	157,739,709.28	155,002,107.31
1.4.12	Зар сурталчилгааны зардал	88,082,917.25	173,591,130.00
1.4.13	Шуудан холбооны зардал	30,733,794.22	81,192,735.48
1.4.15	Зээлийн хүүгийн зардал	1,147,185,685.19	0.00
1.4.17	Хөндлөнгийн хяналт шалгалтын зардал	14,485,350.00	15,009,021.00
1.4.18	Харуул хамгаалалтын зардал	22,932,000.00	27,107,359.60
1.4.19	Даатгалын зардал	2,151,890.00	3,810,834.00
1.4.21	Үнэт цаасны арилжааны зардал	444,323,103.00	556,129,911.48
1.4.22	Ёслол хүндэтгэлийн арга хэмжээний зардал	39,929,167.84	39,974,504.00
1.4.25	Сонин сэтгүүл захиалгын зардал	148,000.00	10,367,824.00
1.4.26	Түрээсийн зардал	7,580,000.00	14,280,000.00
1.4.27	Бусад санхүүгийн зардал	15,050,000.00	
1.4.28	Шимтгэл хураамжийн зардал МХБ	33,112,957.40	587,660,594.48
1.4.29	Шимтгэл хураамжийн зардал ҮЦТХТ	11,323,185.98	421,899,699.92
1.4.30	Шимтгэл хураамжийн зардал СЗХ	6,669,167.64	16,816,848.00
	<i>Гишүүнчлэлийн хураамж</i>	19,800,000.00	36,989,999.91
1.4.31	Бусад шимтгэл	92,403,308.09	140,871,241.94
1.4.32	Үйл ажиллагааны зардлын дүн	3,592,589,198.09	4,202,772,152.97
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(128,846,613.83)	2,608,156,740.78
2	Үндсэн үйл бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	0.00	0.00
2.1.1	Торгууль, хөнгөлөлтийн ашиг (алдагдал)	0.00	0.00

2.1.6	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	15,812,500.29	0.00
2.1.7	Валютын ханшийн зөрүүгийн гарз	(983,985,467.65)	240,416,321.09
2.1.8	Валютын ханшийн өөрчлөлтийн хэрэгжсэн ашиг (алдагдал)	(13,353,206.17)	32,302,711.71
2.1.10	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн олз	(2,232,184,089.07)	457,620,216.12
2.1.12	Санхүүгийн зардал	0.00	2,040,641,887.58
2.1.13	Хандив тусламжийн зардал	(1,800,000.00)	0.00
2.1.14	Бусад зардал	0.00	11,598,548.91
2.2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг /алдагдлын дүн /	(3,215,510,262.60)	1,321,901,187.57
3	Татвар төлөхийн өмнөх ашиг	(3,344,356,876.43)	1,286,255,553.21
3.1	Орлогын татварын зардал	151,758.81	125,121,863.53
4	Татварын дараахь ашиг /алдагдал/	(3,344,508,635.24)	1,161,133,689.68
4.1	Цөөнхөд ноогдох хувь	0.00	0.00
5	Ердийн ажиллагааны ашиг / алдагдал/	(3,344,508,635.24)	1,161,133,689.68
5.1	Онцгой шинжтэй зүйлс (цэвэр дүнгээр)	0.00	0.00
6.0	Тайлант үеийн цэвэр үр дүн	(3,344,508,635.24)	1,161,133,689.68

12-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлтүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг мөн

АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
"БИ ДИ СЕК ҮЦК" ХХК

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	3,659,612,946.55	7,044,396,111.36
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	3,659,015,210.51	6,753,252,854.44
Даатгалын нөхөөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	2,776,596.00
Бусад мөнгөн орлого	597,736.04	288,366,660.92
Мөнгөн зарлагын дүн (-)	10,678,919,535.02	(15,895,336,307.40)
Ажиллагчдад төлсөн	(895,380,935.38)	(1,045,015,964.37)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(233,954,081.54)	(309,201,606.64)
Бараа материал худалдан авахад төлсөн	13,530,701,941.31	(10,749,830,088.09)
Ашиглалтын зардалд төлсөн	(100,987,985.97)	(160,422,732.38)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(4,204,061.00)	(24,966,937.00)
Хүүний төлбөрт төлсөн	(747,394,340.52)	(1,584,817,156.82)
Татварын байгууллагад төлсөн	(220,555,911.58)	(157,177,734.79)
Даатгалын төлбөрт төлсөн	(2,151,890.00)	(3,810,834.00)
Бусад мөнгөн зарлага	(647,153,200.30)	(1,860,093,253.31)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	14,338,532,481.57	(8,850,940,196.04)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Мөнгөн орлогын дүн (+)	4,420,145,106.10	12,337,302,162.24
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	9,700,000.00	0.00
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсаны орлого	4,410,445,106.10	11,160,929,191.87
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан олголт	0.00	1,176,372,970.37
Мөнгөн зарлагын дүн (-)	16,932,582,619.00	(3,749,956,159.58)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	48,286,049.00	(56,441,372.00)
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	16,848,897,834.75	0.00
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа	35,398,735.25	(3,693,514,787.58)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(12,512,437,512.90)	8,587,346,002.66
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	25,842,856,386.89	80,855,664,139.04
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	11,575,850,591.66	26,270,907,484.58
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргасанаас хүлээн авсан	14,241,567,082.11	0.00
Бусад мөнгөн орлого	27,238,713.12	54,584,756,654.46
Төрөл бүрийн хандив	(1,800,000.00)	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	26,782,100,787.44	(80,354,785,599.30)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	11,185,249,067.05	(5,366,363,291.10)
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	(14,943,575,791.55)
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	14,992,553,969.58	(13,027,303,844.78)
Төлсөн ногдол ашиг	597,216,660.00	0.00
Бусад зардал	24,717.22	(46,741,912,663.33)
Ханшийн зөрүүний алдагдал	7,056,373.59	(275,630,008.54)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(939,244,400.55)	500,878,539.74
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	886,850,568.12	237,284,346.36
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,774,085,785.81	2,660,936,353.93
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,660,936,353.93	2,898,220,700.29

12-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг

АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"БИ ДИ СЕК ҮЦК" ХХК

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Дахин үнэлгээний нөөц	Нэмж төлөгдсөн капитал	Эздийн өмчийн бусад хэсэг	(төгрөгөөр)	
					Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,369,488,300.00	3,824,524,382.82	7,957,309,291.00	(600,193,925.70)	0.00	12,551,128,048.12
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	1,591,771,322.94	1,591,771,322.94
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,369,488,300.00	3,824,524,382.82	7,957,309,291.00	(600,193,925.70)	1,591,771,322.94	14,142,899,371.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	1,591,771,322.94	14,142,899,371.06
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	1,161,133,689.68
Өмчид гарсан өөрчлөлт	7,957,274,818.32	0.00	(7,957,274,818.32)	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	9,326,763,118.32	3,824,524,382.82	34,472.68	(600,193,925.70)	2,752,905,012.62	15,304,033,060.74

12-29 дугаар хуудсан дахь тэмдэглэлүүд нь эбгээр санхүүгийн тайлануудын салшгүй хэсэг мөн.

НЭГ. "БИ ДИ СЕК ҮЦК" ХК БОЛОН ТҮҮНИЙ 2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НЭЭР ДУУСВАР БОЛСОН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Эдгээр тэмдэглэлүүд нь өмнөх санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бөгөөд тэдгээртэй хамт уншигдана.

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- *Байршил:* Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг 8 дугаар хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1 "Би Ди Сек ҮЦК" ХК-ний байр Утас1: 976-11-313196, 313108 И-мэйл: info@bdses.mn
- *Өмчийн хэлбэр:* Хувьцаат Компани
- *Харилцдаг санхүү, татварын байгууллага:* Чингэлтэй дүүргийн төрийн сан, татварын хэлтэс
 - *Тайлангийн хугацаа:* 2023 оны 01 сарын 01-нээс 2023 оны 12 сарын 31
 - *Үйл ажиллагааны үндсэн чиглэл:*
 - ✓ Брокер, дилерийн
 - ✓ Андеррайтерийн
 - ✓ Хөрөнгө оруулалтын зөвлөх
 - ✓ Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа
- *Өмнөх аудитор:* Лайэн Аудит ХХК, Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 11-р хороо, Их Монгол улсын гудамж, 511-502 тоот.
- *Аудитор:* "Пантер Мидлан Аудит" ХХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, нарны зам JS тауэр 1002 тоот Утас: 70141770, 95111770

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Би Ди Сек ҮЦК" ХК нь анх 1991 онд "Баяндөхөм" нэртэйгээр Төв аймгийн Зуунмод хотод иргэдийн өмч хувьчлалын тасалбарыг бүртгэх, бичилт хийх ажлыг зохион байгуулах зорилгоор байгуулагдсан. Улсын бүртгэлээс 9010001030 дугаартай, 2052482 тоот регистрийн дугаар бүхий гэрчилгээг авч хөрөнгийн зах зээлд брокер, дилерийн үйл ажиллагаа явуулах зорилгоор "Би Ди Сек" хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөгдөн зохион байгуулагдсан байна.

"Би Ди Сек" хувьцаат компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд Монгол улсад Хөрөнгийн зах зээл үүссэн 1991 оноос хойш тасралтгүй 30 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар дараах төрлийн үйл ажиллагааг явуулж байна.

- Брокер, дилерийн
- Андеррайтерийн
- Хөрөнгө оруулалтын зөвлөхийн
- Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа.

2007 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайг "Би Ди Пи И Эф" ХХК-ийг хөрөнгө оруулалтын чиглэлээр үүсгэн байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд 2007 оны 8-р сарын 15-нд 5157781 регистр бүхий 901117032 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан.

2007 оны 9-р сарын 14-нд "Би Ди Пи И Эф" ХХК-ийн нэрийг "Би Ди Си Эй Пи" ХХК болгон өөрчилсөн. "Би Ди Си Эй Пи" ХХК нь "Би Ди Сек ҮЦК" ХК-ийн үл хөдлөх хөрөнгийг бусдад түрээслүүлэх үйл ажиллагаа эрхэлж байна.

2015 оны 12 сарын 03-нд гадаад худалдааны чиглэлээр байгуулсан 6025862 регистр бүхий 9011577076 тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй "Их Чингис хааны хөмрөг" ХХК-ийг 2019 оны 02 сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн тогтоолоор хөрөнгө оруулалтын менежментийн компани болгон өөрчлөн байгуулж 100,000.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Тус компани нь дараах 4 салбартай

1	Орхон аймаг салбар	Орхон аймаг Хүрэн булаг сум, Харх ХХК-ний байр 205 тоот
2	Дархан аймаг салбар	Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг, Дархан их дэлгүүрийн 6 давхарт, 604 тоот
3	Сайншанд салбар	Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг, Ялалтын гудамж, намын хороо 2 давхарт 116 тоот
4	Төв аймаг салбар	Төв аймаг, Зуунмод сум, 1-р баг, төрийн үйлчилгээний нэгдсэн төв

Гол томоохон хувь нийлүүлэгчид

Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмшиж буй хувь
Монголиан мастер менежмент ХХК	8.87%
Тасган инвест ХХК	15.32%
Д.Даянбилгүүн	17.45%
Zwahr Alexander	24.73%
Импера Монголиа Холдинг	6.25%
Нийт	

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг 2022 оны 04 сарын 25-ний өдрийн №03/2022 тоот тогтоолоор томилсон. Компанийн ТУЗ-д үүсгэн байгуулагчдаас гадна дотоод, гадаадын хөрөнгийн зах зээлийн талаар туршлагатай мэргэжилтнүүд ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөл:

Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн дарга
Н.Батгэрэл	ТУЗ-ийн гишүүн
Б.Лхагвадорж	ТУЗ-ийн гишүүн
О.Уранбайгал	ТУЗ-ийн гишүүн
Улуч Бингол	ТУЗ-ийн гишүүн
Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Б.Энхбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн
М.Туяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн
Хитоши Тани	ТУЗ-ийн хараат бус гишүүн

Гүйцэтгэх удирдлага:

Д.Даянбилгүүн	ТУЗ-ын дарга
Б.Лхагвадорж	"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн гүйцэтгэх захирал
Н.Батгэрэл	"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн тэргүүн дэд захирал
Ш.Шинэбаяр	"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн дэд захирал

Аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайлан нь зөвхөн "Би Ди Сек ҮЦК" ХК болон түүний охин компани "Би Ди Си Эй Пи" ХХК, "Их Чингис Хааны хөмрөг" ХХК-ийнх бөгөөд тоон мэдээллүүд нь Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг /MNT/-өөр илэрхийлэгдсэн байна.

ХОЁР. ТАЙЛАНГИЙН ХУРААНГҮЙ

"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2023 оны завсар үеийн санхүүгийн тайлангийн аудитыг 2024 оны 02 дугаар сарын 11-нээс 2024 оны 03 дугаар сарын 12-ний хооронд гүйцэтгэж, захиалагч болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхээр төлөвлөн, "Пантер мидланд аудит" ХХК-ийн аудитор Ц.Алтанцэцэг, аудиторын туслах Т.Энхсайхан, Д.Батсайхан чанарын хяналтын аудитор Б.Сансармаа нар хариуцаж гүйцэтгэв.

"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны санхүүгийн нийт хөрөнгө, нийт орлого, нийт зардлын аль ихийг сонголоо.

"Би Ди Сек ҮЦК" ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт хөрөнгийн дүн 45,027,297.4 мянган төгрөг, нийт орлогын дүн 6,810,928.8 мянган төгрөг, нийт зардлын дүн 5,649,795.2 мянган төгрөг бөгөөд материаллаг байдлыг дээрх 3 дүнгийн аль ихээс буюу нийт хөрөнгөөс 2 хувиар тооцож 900,545.9 мянган төгрөгөөр тодорхойллоо.

ГУРАВ. "БИ ДИ СЕК ҮЦК" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

Тус компани нь нийтлэг зориулалттай тусдаа санхүүгийн тайлан бэлтгэхдээ дараах бүртгэлийн бодлогуудыг баримтална.

Даган мөрдөх тайлан

Санхүүгийн тайлангууд нь НББОУС-ын Хорооноос гаргаж мөрдүүлсэн СТОУС болон НББОУХ-ны тайлбарын Байнгын Хорооноос гаргасан тайлбарын дагуу бэлтгэгдсэн.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Монгол Улсын Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ыг даган мөрдөнө.

Санхүүгийн тайлан бэлтгэсэн үндэслэл

Санхүүгийн тайланг бэлтгэх зорилго нь байгууллагын хөрөнгө, эх үүсвэр, санхүүгийн байдал, хүлээн зөвшөөрсөн орлого, зарлага, тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээг Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу үнэн зөв илэрхийлэх явдал юм.

Хэмжилтийн үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харах) бусад зүйлсийн хувьд өртөгт түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

- Санхүүгийн хэрэглүүр - Зээл ба авлага хорогдуулсан өртгөөр
- Санхүүгийн хэрэглүүр - Өрийн хэрэгсэлд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн хэрэглүүр - Хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалт бодит үнэ цэнээр
- Санхүүгийн өр төлбөр - Санхүүгийн өр төлбөр хорогдуулсан өртгөөр

НББ-ийн ерөнхий суурь

Компанийн үйл ажиллагааны болоод тайлагнагч валют нь Монгол улсын Төгрөг байна. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнасан.

Тасралтгүй үйл ажиллагааны төсөөлөл

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд тулгуурлан бэлтгэгдсэн. Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг.

Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

Тайлангийн хугацаанд шинээр хэрэгжиж эхэлсэн стандартууд болон бусад стандартын нэмэлт өөрчлөлт

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээ	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалуудыг дараах шинж чанаруудаар бүлэглэсэн байна. Бүлэг-1 Санхүүгийн тайлагналын зорилго Бүлэг-2 Санхүүгийн мэдээллийн хэрэгцээтэй байдлын чанарын үзүүлэлт Бүлэг-3 Санхүүгийн тайлан болон тайлагнагч аж ахуйн нэгж Бүлэг-4 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд Бүлэг-5 Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт Бүлэг-6 Хэмжилт Бүлэг-7 Толилуулга ба тодруулга Бүлэг-8 Капиталын талаарх үзэл баримтлал /ойлголт ба капитал загвар	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх
СТОУС 3 Бизнесийн нэгдэл-Бизнесийн тодорхойлолт (2018 оны 10-р сард гарсан нэмэлт өөрчлөлт)	Бизнес гэж тодорхойлохын тулд хамгийн багадаа багц үйл ажиллагаа болон хөрөнгийг олж авсан байх. Орцыг иж бүрэн процессоор оруулж гарц бий болгодог байна гэж тодотгосон. Мөн үйлчлүүлэгчид бараа болон үйлчилгээг хүргэдэг байх гэж оруулснаас гадна өртөг зардал хэмнэх гэсэн хэсгийг хассан.	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх
НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС8 нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа	Материаллаг байдлын талаарх тодорхойлолтыг нэг ижил ойлголт болгохын тулд тухайлсан нэмэлт өөрчлөлтүүдийг баталсан. Шинэ тодорхойлолтоор мэдээллийг орхигдуулсан, буруу тайлагнасан, гуйвуулсан, бүрхэгдүүлсэн нь тухайн тайлагнагч аж ахуйн нэгжийн талаарх санхүүгийн мэдээллээр хангадаг нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангуудад үндэслэн шийдвэр гаргадаг гол хэрэглэгчдийн шийдвэр гаргалтад нөлөөлнө гэж үзэж байвал материаллаг гэж авч үзнэ	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх

Батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй стандартууд

Компаний санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг дор тодруулсан болно. Эдгээр стандартууд болон өөрчлөлтүүд нь компаний санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхээр бол компани эдгээрийг хэрэгжиж эхэлсэн үеэс дагаж мөрдөнө.

Шинэ стандартууд болон өөрчлөлтүүд:	Хэрэгжих хугацаа:
Нэмэлт өөрчлөлт орсон стандартууд	
СТОУС 3 Бизнесийн тодорхойлолт - үзэл баримтлалын хүрээний талаархи лавлагаа	2022 оны 1 сарын 1
НББОУС 1 ба НББОУС 8 Материалын байдлын Тодорхойлолт-	2020 оны 1 сарын 1
НББОУС 1 Урт болон богино хугацаат өглөгийн ангилал	2023 оны 1 сарын 1
СТОУС 10, НББОУС 28 Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд хөрөнгө худалдах эсвэл хувь оруулалт	Шийдвэр гараагүй
НББОУС 16- Үндсэн хөрөнгө- Ашиглаж эхлэх хугацаанаас өмнөх үндсэн хөрөнгө бэлтгэл	2022 оны 1 сарын 1
НББОУС 37- Хүнд нөхцөлт гэрээ – Гэрээг биелүүлэх өртөг	2022 оны 1 сарын 1
СТОУС-ийн 2018-2020 жилийн СТОУС-н ээлжит сайжруулалт СТОУС-уудын 2017 оны 12 дугаар сард хэвлэн гаргасан нэмэлт сайжруулалтууд	2022 оны 1 сарын 1 2022 оны 1 сарын 1
<ul style="list-style-type: none"> • СТОУС 1- СТОУС анх удаа хэрэгжүүлэгч • СТУУС 9- хэрэгсэл 	
Шинэ стандарт	
СТОУС 17 Даатгалын гэрээ	2023 оны 1 сарын 1

Нягтлан бодох бүртгэлийн чухал тооцоолол ба шийдэл

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон тоног төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэл зэрэг элэгдүүлдэг хөрөнгөнүүдийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйн татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнийн хэмжилт

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнэ нь идэвхтэй зах зээлийн мэдээлэл дээр үндэслэгдээгүй тохиолдолд тэдгээрийн бодит үнэ цэнийг үнэлгээний загваруудыг хамарсан янз бүрийн үнэлгээний арга техникүүдийг ашиглан тодорхойлно.

Боломжтой бол идэвхтэй зах зээл дээрээс эдгээр загваруудад ашиглах мэдээллүүдийг авч үнэлэх ба ийм боломжгүй тохиолдолд бусад мэдээлэл ашиглан бодит үнэ цэнийг тодорхойлно. Идэвхтэй зах зээлийн болон бусад мэдээллүүд нь санхүүгийн байдлын тайланд тусгагдах санхүүгийн хөрөнгөнүүдийн бодит үнэ цэнийг тайлагнахад нөлөөлнө. Үнэлгээний загварууд нь боломжтой тохиолдолд ижил төрлийн хэрэглүүр дэх тухайн үеийн зах зээл дээрх ажиглагдаж байгаа мэдээллээс авсан үнээр төстлөгдэж баталгаажна.

Хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгж тус бүрийн хувьд аливаа үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст тодорхойлдог. Тухайн хөрөнгө эсвэл мөнгө бий болгогч нэгжийг ашиглах ба худалдан борлуулснаас бий болох бодит үнэ цэнэ нь хөрөнгийн дансны үнээс бага байх тохиолдолд үнэ цэнийн бууралтыг авч үздэг.

Эрсдэлийн сан

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 507 тоот тогтоолоор батлагдсан "Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн тухай журам"-ын дагуу өөрсдийн харилцагч, хөрөнгө оруулагчдыг учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор хувь нийлүүлсэн хөрөнгийн гурваас доошгүй хувьтай тэнцэх хөрөнгөөр үйл ажиллагааны эрсдэлээс хамгаалах санг байгуулна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Касс болон банкны харилцах дансанд байгаа мөнгө, хугацаагүй хадгаламж, 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарласан тусгай зориулалт бүхий мөнгөн сан, үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацаатай хөрөнгө оруулалт хамаарна. Эдгээр хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэнэ.

Дансны авлага

Аж ахуйн нэгжийн үндсэн үйл ажиллагааны явцад борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил, үйлчилгээний төлөө худалдан авагч болон холбоотой талаас авах авлагын дүн орно. Дансны авлагыг цэвэр боломжит үнэ цэнээр буюу мөнгөөр хүлээн авахаар тооцоолж буй цэвэр дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд харуулна.

Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ), нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ), бусад татвар, төлбөр, хураамжийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлант хугацааны эцсээрх илүү төлөгдсөн дүн орно. Улирал ба жилийн эцэс дэх татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын дүн нь татвар, нийгмийн даатгалын байгууллагын баталгаажуулсан дүнтэй тэнцүү байна.

Бусад авлага

Бусад байгууллага, хувь хүн, холбоотой талд өгсөн нэг хүртэлх жилийн хугацаатай буюу үйл ажиллагааны нэг циклийн дотор эргэн төлөгдөх эзэл, үндсэн үйл ажиллагаатай холбогдолгүй үүссэн бусад авлага хамаарна.

Бараа материал

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны үед худалдан борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө, үйлдвэрлэлийн дамжлагад байгаа зүйлс болон үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэгдэх материал, хангамжийн зүйлс хамаарна.

Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд л тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон зээллэгийн өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлыг тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн ангилал

Үндсэн хөрөнгийг шинж чанар, үйл ажиллагаанд ашиглагдах байдлаар нь ангилна.

Үүнд:

- (а) Газрын сайжруулалт: Нийтийн эзэмшлийн газар дээр хийгдсэн явган хүний зам, ногоон байгууламж болон бусад газрын сайжруулалтууд;
- (б) Барилга байгууламж: Бүх төрлийн барилга, түүний бүрэлдэхүүнд хамаарах халаалт, ус, агааржуулалт, цахилгааны систем, зам, гүүр, янз бүрийн талбай зэрэг дэд бүтцийн шинжтэй зүйлс;
- (в) Машин, тоног төхөөрөмж: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай бүх төрлийн машин механизмаас гадна дамжуулах төхөөрөмж, нэмэгдэл төхөөрөмжүүд;
- (г) Тээврийн хэрэгсэл: Бүх төрлийн тээврийн хэрэгслүүд;
- (д) Тавилга, эд хогшил: Нэг жилээс дээш хугацаанд ашиглагдах тавилга, аж ахуйн эд хогшил, багаж хэрэгслүүд;
